МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дамбын Догсүм:	Дугаар	L357
Оршин суугаа аймаг	Дундговь аймаг	Оршин суугаа сум	Мандалговь
Төрсөн газар	Хулд сум	Төрсөн он	1921
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Луусын хийд	Сүм хийдийн дугаар	ДУХД 019
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 3	Ярилцлага авсан хүн	Жужа

Дамбын Догсүм

Дундговь аймгийн Луус сумын Дугантын жас

Жужа: Та Дугантын хийдэд хэдэн удаа очиж байсан бэ?

Дамбын Догсүм: Багадаа зөндөө очсон, нутаг юм болохоор.

Жужа: Тэнд хэдэн дуган байсан бэ?

Дамбын Догсүм: 2 дуган байсан, баруун жас зүүн жас гэж.

Жужа: Модон дуган уу?

Дамбын Догсүм: Модон модон. Хоёр модон дуган байсан.

Жужа: Суварга байсан уу, тэнд?

Дамбын Догсүм: Байсан байсан. Хойноо л нэг суварга байсан.

Жужа: Өмнө талдаа байхгүй байсан уу?

Дамбын Догсүм: Үгүй, өмнө талдаа суварга байгаагүй.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

Жужа: Хүрд байсан уу, эргүүлдэг том хүрд?

Дамбын Догсүм: Гадна талдаа байгаагүй. Харин дуган дотроо хоёр хатавчинд нь эргүүлдэг хүрд байсан.

Жужа: Тэр хоёр дуган ямар ямар нэртэй дуган байсан бэ?

Дамбын Догсүм: Нэг нь майдрын дуган гэж байсан.Нөгөөх нь юу гэж байлаа, санахгүй байна. Баруун зүүн жас гэж нэрлэж байсан юм.

Жужа: Нийт хэдэн ламтай байсан бэ?

Дамбын Догсүм: Өө нэг тавиад ламтай, багашаархан хийд байсан юм.

Жужа: Хийдийн тэргүүн, хамгийн том лам нь ямар лам байсан бэ?

Дамбын Догсүм: Ренчин гавж гэж хүн байсан юм.

Жужа: Хутагт хувилгаад гэж байсан уу?

Дамбын Догсүм: Зүгээр л одоо гавж л гэж байснаас хутагт хувилгаад байгаагүй.

Жужа: Тэр дуган байгаа газрын нэр ямар нэртэй газар вэ?

Дамбын Догсүм: Тэр дуган байгуулагдсан газар бол Юнлэдэрсэн ус гэдэг газар. Сүүлдээ хүмүүс дугант л гэдэг болчихсон.

Жужа: Ойр орчимд нь тахидаг уул овоо бий юу?

Дамбын Догсүм: Дугантын их уулын Салхит гэдэг уулыг эртнээс тахиж байсан, одоо ч тахиж байгаа.

Жужа: Майдар эргэж байсан уу?

Дамбын Догсүм: Майдар эргэж байсан. Дуганаа тойроод л гороолоод л .

Жужа: Ганжуур эргэж байв уу?

Дамбын Догсүм: Тэрийг ёстой мэдэхгүй.

Жужа: Цам гарч байсан уу?

Дамбын Догсүм: Цамгүй байсан.

Жужа: Зоч лам лүйжин тавьдаг лам нар байсан уу?

Дамбын Догсүм: Байлгүй яахав, байсан. Өө хэн, хэн билээ, нэрийг нь марьчихаж. Зоч лам нар байсан.

Жужа: Тэр хийд хэдэн онд хаагдсан бэ?

Дамбын Догсүм: За байз хэдэн онд билээ дээ, 1930 оноос эхэлж хаагдаад 1937, 1938 онд бүр зүйл дууссан.

Жужа: Та Дугантын хийдээс өөр хийд хуралд очиж байв уу?

Дамбын Догсүм: Манай энэ Луусын хийд гэж том хийд байсан юм. Хувилгаантай, их л олон дуган суваргатай хийд байсан. тэр Луусын булаг гээд булаг байдаг. Хажуу уулынхаа энгэрт байсан.

Жужа: Хэн гэдэг хувилгаантай байсан юм?

Дамбын Догсүм: Лхагважав гэдэг нэртэй хүн байсан юм.Одоо энэ Луусын хийдийн тухай өнгөрсөн хавар нас барсан Орог гуай л сайн мэдэх байсан. Одоо энэ хүү нь аймгийн төв дээр автын байцаагч, Хүүхэнбаатар гэж хүн

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

бий. Луусын хийдийн хувилгаан Лхагважав гэж хүн Завханаас энд ирж төрсөн хүн. Үхэхийнхээ өмнө миний хойд дүр Завханд төрнө гэсэн юм гэнэ лээ. Тэгээд төрсөн юм гэдэг.Тэгээд энэ Луусынхан залж ирнэ гэж хөөцөлдөөд ирээгүй юм гэнэ лээ.

Жужа: Луусд өөр жижиг жас хурлууд байсан уу?

Дамбын Догсүм: Луусд Хэвтүүлийн хийд, Шувуутын хийд гэж миний мэдэхийн хоёр хийд байсан. Би очиж үзээгүй. Өөр мэдэхгүй.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон